



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/51/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Э.Нандинчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗТХС	Зам Тээвэр Хөгжлийн Сайд
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Агуулга

Аудитын гэрчилгээ	1
Аудитын тайлан.....	3
2.1. Оршил	3
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	4
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	4
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
Менежментийн захидал	8
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	9
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13


**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203
dov.aa.27 № 198
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ЦАГААН-ОВОО
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.НАРАНЦАЦРАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Цагаан-овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Цагаан-овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Цагаан-овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520124



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Цагаан-Овоо сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Б.Наранцацрал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаан-Овоо сумын цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Овоо сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Цагаан-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Цагаан-Овоо сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хичээл хөгжүүлэх үйл ажиллагааны чанарыг сайжруулан үр дүнтэй зохион байгуулж эцэг эх асран хамгаалагчдын дэмжлэгтэйгээр хүүхдийн хөгжил төлөвшилд ахиц гаргах”-д оршино.

Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Үүнд:

- Цэцэрлэгийн үйл ажиллагааг хамтын оролцоотойгоор үнэлж, үр дүнг үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх.
- Багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх, сургуулийн өмнөх насныханд зөв суурийг тавих.
- Хичээл сургалтын үйл ажиллагаанд заах аргын нэгдэл багаар хамтран чанартай бэлтгэх ээлжит хичээлийг хүүхдийн ялгаатай байдал хэрэгцээ сонирхол харгалзан адил тэгш оролцоог хангах үр өгөөжтэй зохион байгуулах чиглэлээр багшийн заах арга ур чадварыг хөгжүүлэх.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Цагаан-Овоо сумын цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Цагаан-Овоо сумын цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Цагаан-Овоо сумын цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 30 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 369,272.8 мянган төгрөгөөс тооцон 5,539.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд тооцсоныг хэвээр авсан.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Цагаан-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,186.21 мянган төгрөгөөр буюу 5,09 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	36,872.42	39,602.42	2,730.00
Үндсэн хөрөнгө	633,712.13	644,584.25	10,872.12
Хуримтлагдсан элэгдэл	(114,356.46)	(158,744.13)	(44,387.66)
Нийт хөрөнгө	556,228.09	525,442.54	(30,785.54)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	556,228.09	525,442.54	(30,785.54)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	556,228.09	525,442.54	(30,785.54)

Бараа материалын дансны үлдэгдэл 2,730.0 мянган төгрөгөөр өссөн нь хүүхдийн ор хөнжлийн даавуу, гал тогооны хэрэгсэл авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,872.1 мянган төгрөгөөр өссөн нь Гал тогооны тоног төхөөрөмж болон тавилга худалдан авсантай холбоотой байна.

Өмнөх оны өр төлбөр дансанд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 525,442.5 мянган төгрөг болж 30,785.5 мянган төгрөгөөр буурсан нь Үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 328,419.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 298,419.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 30,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 328,419.0 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Цагаан-Овоо сумын цэцэрлэг 2019 онд өөрийн орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 30 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэл тогтоож 30 эрсдэл тодорхойлж нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 72,946.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 72,427.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 60,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 352.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Аудитаар дараах 72,487.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Шатахууны 60.0 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтгүй бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь хэсэгт “ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дэх “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд гарсан зардлаас 72,427.3 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 459.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- ✓ Худалдан авалтын гэрээний нэгжийн үнэ, түүний өөрчлөлтийг нягтлан шалгах.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Цагаан-Овоо сумын Цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цагаан-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Цагаан-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1 Илрүүлэлт: Тээвэр шатахууны батлагдсан төсөв 1,443.4 мянган төгрөг байхад гүйцэтгэлээр 1,651.4 мянган төгрөг байгаа нь 208.0 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

1.2 Эрсдэл: Төсөв гүйцэтгэлийн илүү дутууг нөгөөрүү нь гүйлгэсэн байна.

1.3 Өгсөн зөвлөмж: Зардлыг ангилалын дагуу зарцуулж байх.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1 Илрүүлэлт: 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтанд заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 251.5 мянган төгрөгийн зөрүүтэй байсан.

2.2 Эрсдэл: Хөрөнгө арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулагдах.

2.3 Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулалтанд ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалыг мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,872,417.40	39,602,417.40
35	БАРАА МАТЕРИАЛ	36,872,417.40	39,602,417.40
351	Түүхий эд материал	33,358,286.40	36,088,286.40
35110	Тусгай зориулалттай материал	33,358,286.40	36,088,286.40
354	Хангамжийн материал	3,514,131.00	3,514,131.00
35410	Бичиг хэргийн материал	3,514,131.00	3,514,131.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	519,355,668.21	485,840,125.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	519,355,668.21	485,840,125.43
392	Биет хөрөнгө	511,970,668.29	478,647,625.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	366,606,161.22	366,606,161.22
39202	Хуримтлагдсан элэгдэл	(533,333.28)	(10,231,743.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	145,616,065.50	152,696,065.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,719,775.30)	(63,544,215.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,790,606.48	35,775,226.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,256,636.49)	(27,292,589.43)
39209	Зам, гүүрийн байгууламж	73,154,300.00	73,154,300.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(41,966,719.92)	(49,415,579.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,160,000.00	9,160,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,879,999.92)	(8,260,000.00)
393	Биет бус хөрөнгө	7,384,999.92	7,192,499.88
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(385,000.08)	(577,500.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,000,000.00	7,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	556,228,085.61	525,442,542.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	556,228,085.61	525,442,542.83
51	Засгийн газрын хувь оролцоо	556,228,085.61	525,442,542.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	745,183,818.48	745,183,818.48
51101	Өмч: - төрийн	738,183,818.48	738,183,818.48
51102	- төрийн	7,000,000.00	7,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(189,810,853.91)	(220,596,396.69)
51210	Өмнөх үеийн үр дүн	(189,810,853.91)	(189,810,853.91)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(30,785,542.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	855,121.04	855,121.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	556,228,085.61	525,442,542.83

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	293,121,600.00	338,487,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,124,400.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	4,124,400.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,124,400.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,400.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,095,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	288,997,200.00	338,487,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	287,233,600.00	298,419,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	287,233,600.00	298,419,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,763,600.00	10,068,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	168,300.00
131106	Төсвийн урамшуулал	1,763,600.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	30,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	30,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	325,276,011.76	369,272,842.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	325,276,011.76	369,272,842.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	309,132,770.76	369,266,786.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168,430,444.00	207,776,750.00
210101	Үндсэн цалин	136,352,957.00	178,652,350.00
210102	Нэмэгдэл	12,375,000.00	13,533,200.00
210104	Урамшуулал	13,766,487.00	15,591,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,936,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,594,425.00	25,972,600.00
210201	Тэтгэврийн даатгал	13,113,270.00	17,661,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,641,154.00	2,077,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,282,268.00	1,662,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	323,493.00	415,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,234,240.00	4,155,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,200,459.00	26,997,369.00
210301	Гэрэл, цахилгаан	4,698,222.00	6,006,365.00
210302	Түлш, халаалт	15,482,237.00	20,946,004.00
210303	Цэвэр, бохир ус	20,000.00	45,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,064,146.20	5,095,077.00
210401	Бичиг хэрэг	928,900.00	886,650.00
210402	Тээвэр, шатахуун	585,430.00	1,651,467.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,271,280.00	2,556,960.00
210408	Бараа материал акталсны зардал	6,278,536.20	-
2105	Нормативт зардал	59,975,546.00	54,809,328.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,600.00	300,000.00
210502	Хоол, хүнс	59,913,946.00	53,689,328.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	820,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	3,000,000.00
2107	Томилголт, зочны зардал	98,000.00	467,500.00
210702	Дотоод албан томилголт	98,000.00	467,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000.00	568,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	388,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,589,750.56	44,580,162.78
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,589,750.56	44,580,162.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,143,241.00	6,056.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,124,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,124,600.00	-

Цагаан-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,641.00	6,056.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,641.00	6,056.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(32,154,411.76)	(30,785,542.78)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	91,035,000.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	91,035,000.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	171,028,161.86	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	171,028,161.86	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(79,993,161.86)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(112,147,573.62)	(30,785,542.78)

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	289,026,600.00	338,487,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,400.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	29,400.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,400.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	288,997,200.00	338,487,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	287,233,600.00	298,419,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	287,233,600.00	298,419,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,763,600.00	10,068,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	168,300.00
131106	Төсвийн урамшуулал	1,763,600.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	30,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	30,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	289,026,600.00	328,587,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	289,026,600.00	328,587,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	272,883,359.00	328,581,244.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168,430,444.00	207,776,750.00
210101	Үндсэн цалин	136,352,957.00	178,652,350.00
210102	Нэмэгдэл	12,375,000.00	13,533,200.00
210104	Урамшуулал	13,766,487.00	15,591,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,936,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,213,300.00	25,972,600.00
210201	Тэтгэврийн даатгал	13,525,853.00	17,661,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,682,412.00	2,077,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,333,841.00	1,662,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	333,808.00	415,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,337,386.00	4,155,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,200,459.00	26,997,369.00
210301	Гэрэл, пахилгаан	4,698,222.00	6,006,365.00
210302	Түлш, халаалт	15,482,237.00	20,946,004.00
210303	Цэвэр, бохир ус	20,000.00	45,000.00

Цагаан-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	2,785,610.00	6,059,697.00
210401	Бичиг хэрэг	928,900.00	886,650.00
210402	Тээвэр, шатахуун	585,430.00	1,651,467.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,271,280.00	3,521,580.00
2105	Нормативт зардал	59,975,546.00	56,889,328.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,600.00	300,000.00
210502	Хоол, хүнс	59,913,946.00	53,689,328.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	3,000,000.00
2107	Томилголт, зочны зардал	98,000.00	467,500.00
210702	Дотоод албан томилголт	98,000.00	467,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000.00	568,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	388,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	850,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	850,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,143,241.00	6,056.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,124,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,124,600.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,641.00	6,056.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,641.00	6,056.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	9,900,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	9,900,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	9,900,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	9,900,000.00
223001	Бусад хөрөнгө	-	9,900,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(9,900,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	745,183,818.48	855,121.04	(189,810,853.91)	-	556,228,085.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	745,183,818.48	855,121.04	(189,810,853.91)	-	556,228,085.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	745,183,818.48	855,121.04	(189,810,853.91)	-	556,228,085.61
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	745,183,818.48	855,121.04	(189,810,853.91)	-	556,228,085.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	745,183,818.48	855,121.04	(189,810,853.91)	-	556,228,085.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(30,785,542.78)	-	(30,785,542.78)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	745,183,818.48	855,121.04	(220,596,396.69)	-	525,442,542.83

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	328,419,000.00	328,412,944.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	328,419,000.00	328,412,944.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	328,419,000.00	328,412,944.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,779,600.00	207,776,750.00
210101	Үндсэн цалин	178,655,200.00	178,652,350.00
210102	Нэмэгдэл	13,533,200.00	13,533,200.00
210104	Урамшуулал	15,591,200.00	15,591,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,972,600.00	25,972,600.00
210201	Тэтгэврийн даатгал	17,661,500.00	17,661,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,077,900.00	2,077,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,662,100.00	1,662,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	415,700.00	415,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,155,400.00	4,155,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,000,000.00	26,997,369.00
210301	Гэрэл, цахилгаан	7,671,300.00	6,006,365.00
210302	Түлш, халаалт	18,528,700.00	20,946,004.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	45,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,891,400.00	5,891,397.00
210401	Бичиг хэрэг	1,798,000.00	718,350.00
210402	Тээвэр, шатахуун	1,443,400.00	1,651,467.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,650,000.00	3,521,580.00
2105	Нормативт зардал	56,889,900.00	56,889,328.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	53,689,900.00	53,689,328.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,900,000.00	2,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2107	Томилголт, зочны зардал	467,500.00	467,500.00
210702	Дотоод албан томилголт	467,500.00	467,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	568,000.00	568,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	388,000.00	388,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	850,000.00	850,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	850,000.00	850,000.00

